



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 06 өдөр

Дугаар А/404

Есөнбулаг

Хантайшир уулын аймгийн 100 жилийн  
түүхэн ойн бэлтгэл ажил хангах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2023 оны "Зарим аймаг байгуулагдсаны ойг тэмдэглэх болон баяр наадмын хугацааг тогтоох тухай" 221 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн "Аймгийн төсөв батлах тухай" 23 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 27 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Хантайшир уулын аймгийн 100 жилийн түүхэн ойг тэмдэглэхтэй холбогдуулан бэлтгэл ажлын хүрээнд ёслол, хүндэтгэлд шаардагдах зүйлсийг урьдчилан бэлтгэж хариуцан ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Я.Жаргалцэцэг)-т даалгасугай.

2.Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 19,450,000 (арван есөн сая дөрвөн зуун тавин мянга) төгрөгийг орон нутгийн төсвийн урсгал зардалд батлагдсан Хантайшир уулын аймгийн 100 жилийн ойн бэлтгэл ажлыг хангах зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3.Хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, үр дүнг тайлагнахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Я.Жаргалцэцэг)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2023 оны 07  
дугаар сарын 06-ны өдрийн 1741 дугаар  
захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Хармаг	40	60.000	2,400,000
2	Хоормог, сүү, цагаан идээ			17,050,000
	Нийт дүн			19,450,000

\_\_оОо\_\_

